



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 11 сарын 24-өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

### “АПУ” ХК-д “Эвэргрийн Инвестмент” ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “АПУ” ХК-ийн нийт гаргасан нэг бүр нь 10 /арав/ мөнгөний нэрлэсэн үнэ бүхий нийт 742,877,000 /долоон зуун дөчин хоёр сая найман зуун далан долоон мянга/ ширхэг хувьцааг тус компанийд нэгдэж буй “Эвэргрийн Инвестмент” ХХК-ийн хөрөнгөд ногдох нэг бүр нь 10 /арав/ мөнгөний нэрлэсэн үнэ бүхий 321,304,553 /гурван зуун хорин илгэн сая гурван зуун дөрвөн мянга таван зуун тавин гурав/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нийт нэг бүр нь 10 /арав/ мөнгөний нэрлэсэн үнэтэй 1,064,181,553 /нэг тэрбум жаран дөрвөн сая нэг зуун наян илгэн мянга таван зуун тавин гурав/ ширхэг хувьцаа болгон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгож, нэмж гаргаж буй хувьцааны өмчлөх эрхийг энэхүү тогтоолын хавсралтад заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд баталгаажуулан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “АПУ” ХК /Ц.Эрдэнэбилэг/-д үүрэг болгосугай:

1/ Тогтоол батлагдсантай холбогдуулан хууль тогтоомжид заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг шинэчилсэн дүрэмд тусгаж Оюуны өмч, улсын бүртгэлийн газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 20 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;

2/ 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тэнцэлд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгах;

3/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн

мэдээллийн ил тод байдлын журам"-д заасан мэдээллийг тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

4/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан "Компанийн засаглалын кодекс"-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны  
2017 оны 11 дүгээр сарын 24.-ны өдрийн  
224.. дугаар тогтоолын хавсралт

УХД0410 5043225

№	Хувьцаа эзэмшигчийн нэр, /Регистрийн дугаар/	Хувьцааны иэрлэсэн үнэ	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны үнийн дүн /₩/ -	Эзэмших хувь
1	Хайнекен Азия Пасифик Пte.Лтд /РД: 193100007К/	10 мөнгө	266,091,981	26,609,198.10	25 %
2	Монголиан Бэвэриж Инвестмент ХХК /РД: 6133819/	10 мөнгө	55,212,572	5,521,257.20	5.19 %
	Нийт	10 мөнгө	321,304,553	32,130,455.30	30.19 %